



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/56

Сүхбаатар сум

Шуурхай штаб байгуулж, ажлын тусгай  
горимд шилжүүлэх тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1, 33.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг шуурхай хүртээмжтэй хүргэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиуд, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулсугай.

2. Аймгийн шуурхай штабыг нэгдүгээр, шуурхай штабын жижүүрийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шуурхай штабыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын бага танхимд байгуулж, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг мэдээллийн технологи, дэтоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн /Ч.Гандүүрэн/-д даалгасугай.


4. Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, аймгийн хэмжээнд онцгой комиссын орлогч дарга, онцгой байдлын газрын даргаар ахлуулсан, сум орон нутаг, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги тус бүр гамшгаас хамгаалах байнгын ажиллагаатай шуурхай штабыг байгуулж, хариуцлагатай жижүүр, эргүүлийг томилгоожуулан мэдээ, мэдээллийг үнэн зөв шуурхай дамжуулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүх шатны Засаг дарга, аж ахуй нэгж, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Сум орон нутгийнхаа хэмжээнд ариутгал, халдваргүйжүүлэлтийн баг томилгоожуулан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

430801157

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүрд танилцуулж байхыг шуурхай штабын дарга, Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/-д даалгасгай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Ж.САЙНЦОГ



Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн  
А/56 тоот захирамжийн 2 дугаар хавсралт

ШУУРХАЙ ШТАБЫН ЖИЖУУРИЙН ХУВААРЬ

д/д	Овог нэр	Албан тушаал	Утас	2 сар		3 сар																																	
				27	28	29	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30			
1	Б.Мөнхтөр	Аймгийн ХХААГ-ын дарга	99093285																																				
2	З.Тувшинтөгс	Аймгийн БОАЖГ-ын дарга	91118244																																				
3	Н.Алтангэрэл	Аймгийн Тагнуулын газрын дарга	99058084																																				
4	Б.Саруултөгс	Аймгийн ГХБХБ-ын газрын дарга	91111137																																				
5	М.Рэгээдмаа	Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга	99499915																																				
6	Б.Ундрах	"Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨК	91112656																																				
7	Ц.Пүрэвдорж	Монголын Цахилгаан Холбоо ХХК	99495559																																				
8	Б.Монхтулга	УБТЗ-ын Сүхбаатар өртөөний дарга	86114120																																				
9	Н.Эрдэнэбат	Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга	99241401																																				
10	Э.Сувдаа	"ДСЦС"-ний Сүхбаатар салбарын дарга	99077597																																				

МКОА0005 9055053



